



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ДУГААР 16



ШҮҮХИЙН АКАДЕМИ

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

10,11
CAP

2024.12.02 - Дугаар/16/



ШҮҮХИЙН АКАДЕМИ, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА (IDLO)-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-аас хэрэгжүүлж буй “Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод байдал” төслийн нээлтийн арга хэмжээ 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр болж, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Монголын хуульчдын холбоо зэрэг байгууллагууд Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-тай хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Тус төслийн хүрээнд Иргэний нийгмийн байгууллага, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааны нөхцөл байдлын суурь болон төгсгөлийн судалгааг боловсруулах, Шүүхийн байранд иргэдэд хууль зүйн зөвлөн туслах үйлчилгээ өгөх эрх зүйн хөтчийг туршилтаар ажиллуулах, Хэвлэл мэдээллийн байгууллагын 25 төлөөллийг хууль эрх зүй, шүүхийн тогтолцоо, хүний эрхийн талаар суурь мэдлэг олгох болон хэргийн тойм мэдээ бичих ур чадвар олгох сургалтад хамруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв, ялгаварлан гадуурхалтгүй, хүний эрхийг дээдэлсэн тайлан мэдээ бэлтгэх зөвлөмжийг боловсруулах зэрэг шат дараатай ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ СЭТГҮҮЛИЙН ШИНЭ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академиас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний улирал тутмын “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн 109 дэх буюу 2024 оны 3-р улирлын шинэ дугаар хэвлэгдэн гарлаа.

Энэ улирлын дугаарт “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн эрх хэмжээ: “Non reformatio in peius” буюу шүүгдэгчийн давж заалдах эрхийг хязгаарлахгүйгээр шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах зарчмын тухай”, “Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэл, төрөл, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба халшрах үр нөлөөний хамаарал”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим”, “Үндсэн хуулийн өмнөх (1992) патентын эрх зүйн зохицуулалт”, “Шүүхийн цахимжилт: харьцуулсан судалгаа” зэрэг судалгааны бүтээлүүд тус тус нийтлэгдлээ.



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН
АКАДЕМИ

МОНГОЛЫН ТӨР, ЭРХ
ЗҮЙ СЭТГҮҮЛИЙН №109
ДЭХ ДУГААР ХЭВЛЭГДЭН
ГАРЛАА



БАРУУН БҮСИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН СУРГАЛТ, УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Шүүхийн академи Улсын дээд шүүхтэй хамтран шүүгчдийн заавал судлах, мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулж Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах болон анхан шатны шүүх, мөн аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн шүүгчид оролцон мэдлэгээ бататгаж, туршлага солилцлоо.

Сургалтыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, шүүгч Ч.Хосбаяр, шүүгч Х.Батсүрэн, Б.Батбаатар, Н.Батчимэг,

С.Соёмбо-Эрдэнэ, П.Золзаяа, М.Батсуурь нар удирдан явуулав.

Тус бүсчилсэн сургалт нь Хэнтий аймагт энэ оны 9 дүгээр сард зохион байгуулсан бүсийн уулзалт, сургалтын нэгэн адил эрүү-иргэний болон иргэн-захиргааны хэргийн шүүхийн аль алинд хамаарах асуудлыг хөндөж, дагнасан шүүхийн шүүгчдийг нэгтгэн хамруулснаар ач холбогдолтой байсныг онцлох нь зүй.

Энэхүү сургалт, уулзалтад нийт 52 шүүгч хамрагдав.

LIKE US ON
FACEBOOK:

ШҮҮХИЙН АКАДЕМИ



www.jtrii.mn

LINKED IN:

JUDICIAL ACADEMY OF
MONGOLIA

ОРОН НУТГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь орон нутгийн Иргэний хэргийн шүүхийн шүүгчдэд зориулсан сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 17-ны өдрүүдэд орон нутагт 4 бүсэд зэрэг зохион байгууллаа.

Архангай аймагт Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх, Дархан-Уул аймагт Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сум дахь сум дундын шүүх, Дорноговь аймагт Дорноговь, Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах болон Иргэний хэргийн анхан шатны шүүх, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, Орхон аймагт Орхон, Булган, Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах болон Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид тус тус хамрагдахаар орон нутгийн сургалтыг бүсчлэн зохион байгууллаа.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНД ТЭРГҮҮЛСЭН ШҮҮГЧ НАР ЯПОН УЛСАД “СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ” СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академитай хамтран Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны 20 жилийн ойд зориулсан дотоодын эрдэм шинжилгээний хурлын үеэр захиргааны хэргийн шүүгч нарын дунд зарласан эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд судалгааны сэдэв, ач холбогдол, эрх зүйн онолын мэдлэг, шинжлэх ухааны судалгааны арга зүйгээрээ шалгарсан 8 илтгэлийг хэлэлцүүлснээс шилдэг илтгэл хэлэлцүүлсэн шүүгчийг судалгааны арга зүйн сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн юм. Шилдэг илтгэлээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Мөнхтулга, Нийслэл дэх Захиргааны

хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Дуламсүрэн нарын “Res judicata зарчим ба захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах асуудал” сэдэвт илтгэл шалгарсан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 25-ны өдрүүдэд Япон улсын Нагояагийн их сургуульд судалгааны арга зүйн сургалтад хамрагдлаа.

ШҮҮГЧ НАР БОЛОН ШҮҮХИЙН АКАДЕМИЙН АЛБАН ХААГЧИД ЯПОН УЛСАД ТУРШЛАГА СУДАЛЛАА


Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь Япон улсын Нагояагийн их сургуулийн Азийн эрх зүйн солилцооны төв (CALE)-тэй байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс 25-ны өдрүүдэд тус Академийн албан хаагчид болон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Мөнхтулга, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Дуламсүрэн, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.Лхагвасүрэн, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Сарантуяа нар Япон улсад туршлага судлах сургалтад хамрагдав. Энэхүү туршлага судлах сургалтын үеэр Япон улсын Нагояагийн их сургуулийн Хууль зүйн ахисан түвшний сургуулийн профессор Акиро Фүжимотогийн “Судалгааны арга зүй”, Аичи мужийн барын холбооны “Хэрэглэгчийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах” сэдэвт сургалтад тус тус хамрагдаж, Нагояа дүүргийн шүүхийн иргэний хэргийн шүүх хуралдааны үйл явцыг ажиглан “Шүүхийн шийдвэрийн ил тод байдал” сэдвийн хүрээнд санал солилцов.



"ХҮН ХУДАЛДААЛАХ, ТҮҮНТЭЙ ТӨСТЭЙ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: АСУУДАЛ, ШИЙДЭЛ" ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ШҮҮХИЙН АКАДЕМИ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Азийн сан "Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт Шүүхийн академийн судлаачдын хийж гүйцэтгэсэн "Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ: харьцуулсан судалгаа"-ны үр дүн, зөвлөмжийг Шүүхийн судалгааны төвийн эрүүгийн эрх зүйн секторын эрхлэгч О.Инжиннаш танилцууллаа.

Тус хэлэлцүүлгээр 2023 онд зохион байгуулсан хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлснээс гадна байгууллагын төлөөллүүд энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх олон улсын болон дотоодын чиг хандлага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлын хүрээнд санал солилцлоо.



ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Шүүхийн сургалт, судалгаа мэдээллийн академи Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдэд зориулсан мэргэшүүлэх сургалтыг орон нутгийн 6 бүсэд 9, 10 дугаар сард, 10 дугаар сарын 28-ны өдрөөс 11 дүгээр сарын 6-ны өдрүүдэд нийслэлд 6 ээлжээр тус тус зохион байгууллаа. Өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ удаагийн мэргэшүүлэх сургалтын онцлог нь 1 ээлжийн сургалт 3 өдрийн турш үргэлжилсэн бөгөөд суралцагч шүүгчдийг цөөн тоогоор ангид хуваарилан зохион байгуулсан нь тэдний идэвх оролцоонд тулгуурласан илүү интерактив хэлбэрийн сургалт болж өндөрлөсөн юм.

Түүнчлэн сургалтын сэдэв нь шүүгчийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласнаас гадна 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд "Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа" буюу "Долоодугаар бүлэг" шинээр нэмсэнтэй холбоотой хуулийн шинэлэг зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэглэх талаар асуудлыг хөндсөн нь цаг үеэ олсон ач холбогдолтой байлаа.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи Эрүүгийн хэргийн шүүхийн шүүгчдийн мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд "Гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох, нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжийн хэрэглээ, шүүхийн практик", "Баривчлах ажиллагаа ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний шүүхийн хяналт", "Авлигын гэмт хэргийн талаарх эрх зүйн шинэ зохицуулалтууд ба хэрэглэхэд анхаарах асуудал", "Авлигатай тэмцэх болон мөнгө угаах гэмт хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа" зэрэг сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

Энэ удаагийн сургалтыг Улсын дээд шүүхийн шүүгч, Иргэний



хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг болон шүүгч М.Пүрэвсүрэн, Б.Батцэрэн, С.Соёмбо-Эрдэнэ, Н.Баярмаа, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Зориг, шүүгч Д.Очмандах, Г.Ганбаатар, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Батаа нар удирдан явуулсан бөгөөд зочин багшаар АНУ-ын Калифорни мужийн дүүргийн шүүхийн шүүгч Роберт С.Хуи шүүгчдэд өөрийн мэдлэг туршлага хийгээд авлига, мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, онцлог түүнтэй холбоотой хэргийг хэрхэн хянан шийдвэрлэж буй талаар олон улсын жишиг, практикийг хуваалцсанаараа ач холбогдолтой байв.

Шүүгчийн заавал судлах, мэргэшүүлэх тус сургалтад нийт 170 шүүгч хамрагдлаа.

ШҮҮХИЙН АКАДЕМИЙН СУДЛААЧ ИТАЛИ УЛСАД СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Европын холбооны дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас хэрэгжүүлж буй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төслийн дэмжлэгтэйгээр Монголын хөнгөн аж үйлдвэрийн салбарын нийгмийн түншлэгч талуудын төлөөлөл Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын дэргэдэх ОУ-ын сургалтын төв (ITCIL-O)-өөс “Олон Улсын хөдөлмөрийн хэм хэмжээ ба хариуцлагатай бизнес: Хүний эрхийн магадлан шинжилгээний хөдөлмөртэй холбоотой асуудлууд” сэдэвт сургалтыг Итали Улсын Турин хотод 2024 оны 11 дүгээр сарын 04-ны өдрөөс 08-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус сургалтад Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Иргэний эрх зүйн секторын эрхлэгч А.Нэмүүлэн болон ХХААХҮЯ, ХНХЯ, Монголын Хуульчдын Холбоо, Монголын Хөнгөн аж үйлдвэрлэлийн ҮЭ-ийн холбоо, Монголын Ноос ноолуурын холбооны төлөөллүүд хамрагдав.



ОЛОН УЛСЫН ШҮҮХИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 11 ДҮГЭЭР ХУРАЛД ОРОЛЦЛОО



Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал Д.Эрдэнэчимэг нар БНСУ-ын Сөүл хотод 2024 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөс 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан “Шүүхийн шинэчлэлт: Шүүхийн ирээдүйн үйл ажиллагаанд бэлтгэх, хүний эрх, техник технологи, үр дүнтэй сургалтын арга зүйг нэвтрүүлэх нь” сэдвээр Олон улсын шүүхийн сургалтын байгууллага (IOJT), БНСУ-ын Шүүхийн судалгаа, сургалтын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан Шүүхийн боловсон хүчнийг бэлтгэх олон улсын 11 дүгээр бага хуралд оролцлоо.

“ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ШҮҮХИЙН АКАДЕМИ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл” хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт Шүүхийн академийн судлаачдын хийж гүйцэтгэсэн “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлд холбогдох судалгаа”-ны үр дүн, саналыг тус Академийн Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч Н.Хулан танилцуулав. Тус судалгаанд “2010-2017 онд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл харьцангуй сайн буюу дунджаар 62.6 хувийн үзүүлэлттэй байсан бол 2018-2023 онд биелэлтийн хувь хэмжээ 47.8 болж буурсан үзүүлэлттэй байна. Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл буурч байгаа нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх нарийвчилсан зохицуулалт хангалтгүй, шүүхийн шийдвэр биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага сул төдийгүй шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь захиргааны байгууллага, албан тушаалтантай харилцахад хүндрэл бэрхшээл тулгардагтай холбоотой гэсэн судалгааны үр дүн гарсан” гэдгийг тодотгож байв.



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН СУДЛААЧИД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР АНУ-ЫН ТУРШЛАГА СУДЛАВ



Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Авлигатай тэмцэх болон мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн удирдагч багшаар АНУ-ын Калифорни мужийн дүүргийн шүүхийн шүүгч Роберт С.Хуи ажилласан бөгөөд тэрээр 12 жил прокуророор ажилласнаас санхүү болон авлига, албан тушаал, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэргүүд дээр түлхүү ажиллаж байжээ. Тэрээр “Авлигын соёлыг дэлгэрүүлж, олон нийтийн дунд хэвшмэл ойлголт төрүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийн сэдлийг улам нэмэгдүүлдэг” хэмээн онцолж байлаа.